

ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан,
төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ДОА-2022/09/НА/СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Чойбалсан хот
2022 он

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,
Тэргүүлэх аудитор: Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn
Аудитын менежер: И.Сэмжидмаа
Утас: 7058-4207, Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn
Ахлах аудитор: Д.Нармандах
Утас: 7058-4207, Цахим хаяг: narmandakhd@audit.gov.mn
Гэрээт аудитор: Б.Оюунхэрлэн
Утас: 7058-4204, Цахим хаяг: oyunkherlenb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын санал дүгнэлт	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	3
3. Аудитын тайлан	11
3.1 Ерөнхий зүйл	11
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	11
3.4 Материаллаг байдал	11
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	122
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	122
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	13
3.8 Аудитын гол асуудал	13
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	13
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	13
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	13
4. Аудитын илрүүлэлт	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл	14





Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт

1.Аудитын санал дүгнэлт



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

21000 Дорнод аймаг, Хөвсгөл сум, Түр байр
УТП-ын 2 байр, Утас/факс: 7058-4303

Ауд. А. 21 № 80

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Б.БОЛОРТУУЛ

011020839



2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,248,405.00</u>	<u>3,248,405.00</u>
35	БАРАА МАТЕРИАЛ	2,248,405.00	3,248,405.00
354	Хангамжийн материал	2,248,405.00	3,248,405.00
35420	Аж ахуйн материал	2,248,405.00	3,248,405.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>29,179,955.75</u>	<u>22,393,900.91</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	29,179,955.75	22,393,900.91
392	Биет хөрөнгө	29,179,955.75	22,393,900.91
39203	Авто-тээврийн хэрэгсэл	45,000,000.00	45,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(35,833,333.35)	(39,166,666.71)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	5,867,886.00	5,867,886.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	(329,934.60)	(1,349,673.12)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	24,399,829.00	24,399,829.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,924,491.30)	(12,357,474.26)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>31,428,360.75</u>	<u>25,642,305.91</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>31,428,360.75</u>	<u>25,642,305.91</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	31,428,360.75	25,642,305.91
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	36,898,407.46	36,898,407.46
51101	Өмч: - төрийн	36,898,407.46	36,898,407.46
512	Хуримтлагдсан үр дүн	(6,580,620.04)	(12,366,674.88)
51210	Өмнөх үеийн үр дүн	(6,580,620.04)	(6,580,620.04)
51220	Тайлант үеийн үр дүн	-	(5,786,054.84)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,110,573.33	1,110,573.33
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>31,428,360.75</u>	<u>25,642,305.91</u>



2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	92,662,553.33	71,020,900.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,046,953.33	21,171,440.66
1200	Нийтлэг татварын бус орлого	29,046,953.33	21,171,440.66
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Үндсэн хөрөнгө	27,041,048.33	21,171,440.66
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого- Бараа материал	2,005,905	0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	63,615,600.00	71,020,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,000,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	62,615,600.00	70,020,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,615,600.00	70,020,900.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	68,979,942.78	76,806,954.84
21	УРСГАЛ ЗАРДАЛ	68,979,942.78	76,806,954.84
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	68,817,249.78	76,166,944.28
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,510,627.00	40,176,289.44
210101	Үндсэн цалин	32,978,827.00	33,272,089.44
210104	Урамшуулал	7,531,800.00	6,904,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,122,300.00	4,452,500.00
210201	Тэтгэврийн даатгал	2,900,900.01	2,874,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	305,300.00	394,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	244,300.00	315,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	61,100.00	78,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	610,700.00	788,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	10,233,000.00	9,157,400.00
210401	Бичиг хэрэг	844,000.00	979,400.00
210402	Тээвэр, шатахуун	7,727,000.00	7,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	300,000.00
210404	Ном, хэвлэл	195,000.00	378,000.00

210408	Бараа материал акталсны зардал	1,167,000.00	
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	8,042,700.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	8,042,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,677,200.00	3,365,600.00
210702	Дотоод албан томилолт	900,000.00	800,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	777,200.00	2,565,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	656,780.00	486,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,100.00	150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	114,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,680.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,117,342.78	10,486,054.84
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	920,000.00	3,700,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	4,197,342.78	6,786,054.84
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,693.00	640,010.56
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	162,693.00	640,010.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	162,693.00	640,010.56
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>(5,364,342.78)</u>	<u>(5,786,054.84)</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>(5,364,342.78)</u>	<u>(5,786,054.84)</u>

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	36,898,407.46	1,110,573.33	-30,263,230.59	7,745,750.20
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,898,407.46	1,110,573.33	-30,263,230.59	7,745,750.20
C07	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	23,682,610.55	23,682,610.55

C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,898,407.46	1,110,573.33	-6,580,620.04	31,428,360.75
D01	2021 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	36,898,407.46	1,110,573.33	-6,580,620.04	31,428,360.75
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	36,898,407.46	1,110,573.33	-6,580,620.04	31,428,360.75
D08	Тайлант үеийн үр дүн			-5,786,054.84	-5,786,054.84
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	36,898,407.46	1,110,573.33	-12,366,674.88	25,642,305.91

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	63,615,600.00	71,020,900.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	63,615,600.00	71,020,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		
		1,000,000.00	1,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,000,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих		
		62,615,600.00	70,020,900.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	62,615,600.00	70,020,900.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	63,615,600.00	71,020,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	63,615,600.00	71,020,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	63,452,907.00	70,380,889.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		
		40,510,627.00	40,176,289.44
210101	Үндсэн цалин	32,978,827.00	33,272,089.44
210104	Урамшуулал	7,531,800.00	6,904,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,122,300.00	4,452,500.00
210201	Тэтгэврийн даатгал	2,900,900.00	2,874,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	305,300.00	394,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	244,300.00	315,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	61,100.00	78,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	610,700.00	788,900.00

2104	Хангамж, бараа материалын зардал	9,066,000.00	9,457,400.00
210401	Бичиг хэрэг	844,000.00	979,400.00
210402	Тээвэр, шатахуун	7,727,000.00	7,500,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	300,000.00
210404	Ном, хэвлэл	195,000.00	378,000.00
2105	Нормативт зардал	-	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,500,000.00	8,042,700.00
210604	Урсгал засвар	6,500,000.00	8,042,700.00
2107	Томилолт, зочны зардал	1,677,200.00	3,365,600.00
210702	Дотоод албан томилолт	900,000.00	800,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	777,200.00	2,565,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	656,780.00	486,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	160,100.00	150,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	240,000.00	-
210803	Даатгалын үйлчилгээ	-	114,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	234,680.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	920,000.00	3,700,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	920,000.00	3,700,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	162,693.00	640,010.56
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	162,693.00	640,010.56
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	162,693.00	640,010.56
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		




2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	70,020,900.00	69,380,889.44
21	УРСГАЛ ЗАРДАЛ	70,020,900.00	69,380,889.44
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	70,020,900.00	69,380,889.44
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	40,816,300.00	40,176,289.44
210101	Үндсэн цалин	33,284,500.00	33,272,089.44
210104	Урамшуулал	7,531,800.00	6,904,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,452,500.00	4,452,500.00
210201	Тэтгэврийн даатгал	2,874,800.00	2,874,800.00
210202	Тэтгэмжийн даатгал	394,400.00	394,400.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	315,500.00	315,500.00
210204	Ажилгүйдлийн даатгал	78,900.00	78,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	788,900.00	788,900.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,457,400.00	8,457,400.00
210401	Бичиг хэрэг	579,400.00	579,400.00
210402	Тээвэр, шатахуун	7,200,000.00	7,200,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	300,000.00	300,000.00
210404	Ном, хэвлэл	378,000.00	378,000.00
2105	Нормативт зардал	1,000,000.00	1,000,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,042,700.00	8,042,700.00
210604	Урсгал засвар	8,042,700.00	8,042,700.00
2107	Томилолт, зочны зардал	3,365,600.00	3,365,600.00
210702	Дотоод албан томилолт	800,000.00	800,000.00

210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	2,565,600.00	2,565,600.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	486,400.00	486,400.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	150,000.00	150,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	114,400.00	114,400.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	200,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	22,000.00	22,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,400,000.00	3,400,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,400,000.00	3,400,000.00
3	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	70,020,900.00	70,020,900.00
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	70,020,900.00	70,020,900.00
320001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	70,020,900.00	70,020,900.00

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
11000	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
14	Орлого	1,000,000.00
140020	Дансны орлого	1,000,000.00
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	700,000.00
210401	Бичиг хэрэг	400,000.00
210402	Тээвэр, шатахуун	300,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	300,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-



3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Д.Нармандах, гэрээт аудитор Б.Оюунхэрлэн нар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа, газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул нар тус тус хэрэгжүүлсэн.

Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн 02/03 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Сум, дүүргийн Хурал нь Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Засгийн газар, яам, агентлаг, дээд шатны Хуралд болон төрийн эрх бүхий бусад байгууллага, албан тушаалтанд хуулиар харьяалуулснаас бусад тухайн нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн болон зохион байгуулалтын ямар ч асуудлыг хэлэлцэж, бие даан шийдвэр гаргах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны нийт зардлын 69.0 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 1.0 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 0.8 сая төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.



3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Бараа материалын дансны үлдэгдэл 3.2 сая төгрөг болж 1.0 сая төгрөгөөр өссөн нь худалдан авалттай холбоотой байна. Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансанд хөдөлгөөн ороогүй, урьд оны үлдэгдлээр байна.

Санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 21.6 сая төгрөгөөр өссөн байна. Энэ нь тайлант онд үнэ төлбөргүй хүлээн авсан орлого байхгүй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 7.8 сая төгрөгөөр өссөн нь зочин төлөөлөгч хүлээн авах зардал болон бараа үйлчилгээний бусад зардал өссөнтэй холбоотой байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 97.3 сая төгрөгөөр, нийт зарлагыг 97.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 70.0 сая төгрөгийн төсөв баталснаас 59.1 сая төгрөгийг улсын төсвөөс, 10.9 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 59.1 сая, орон нутгийн төсвөөс 10.9 сая төгрөгийн санхүүжилт авч нийт 70.0 сая төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд зарцуулсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 69.4 сая төгрөг буюу 99.1 хувийн гүйцэтгэлтэй буюу 0.6 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд 1.0 сая төгрөгийн санхүүжилт орсон бөгөөд бараа үйлчилгээний зардалд зарцуулсан байна.



3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ, үйл явдал гараагүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал нь Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 2021 оны төсвийн хуваарь, түүний гүйцэтгэл, санхүүгийн тайлан, дараа жилийн төсвийн төсөл, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэрэг тоо мэдээллийг хуулийн хугацаанд байршуулсан байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 36.2 сая төгрөгийн албан шаардлагыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.


3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц чухал асуудал гараагүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 2.4 сая төгрөгийн алдаа зөрчил илэрч, албан шаардлага хүргүүлсэн.

4.1 Албан шаардлага



Төсвийн нийт зарцуулалт 99.1 хувьтай байна. Үүнд хэмнэлт хийх боломжтой сургалт, семинар болон зочид төлөөлөгч хүлээн авах зардлыг 100 хувь зарцуулсан байгаа нь Засгийн газрын 2021 оны төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай 43 дугаар тогтоолын 1.5 “салбарын хэмжээнд хийх сургалт, семинар, хурал, зөвлөгөөн болон газар дээрх хяналт-шалгалт зэргийг цахим хэлбэрээр зохион байгуулж, сургалт, семинар, хурал, зөвлөгөөн зэрэг арга хэмжээний болон дотоод албан томилолтын зардлыг хэмнэх,” заалтыг хэрэгжүүлээгүй байна. Тухайн зардлууд нийт 5.9 сая төгрөгийн төсөв, гүйцэтгэлтэй байгаа бөгөөд тухайн төсвийн 40 хувийг хэмнэх боломжтой байсан гэж үзээд 2.4 сая төгрөгийн албан шаардлага хүргүүлээ.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/сая төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
1	Халхгол сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурал	1	2.4					1	2.4		